**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ**
# ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020. оны 02 сарын 16 өдөр Дугаар А/04 Арвайхээр

Эмнэлгийн ор дэлгэх, шаардагдах нөөцийг бүрдүүлэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 13.4.7 дахь заалт, Гамшигийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.5 10.3.6 дахь заалт, шинэ коронавирусийн халдварын эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Шинэ коронавирусийн халдварын үед дайчлан ажиллах эмнэлэг, тасаг нэгжийг хавсралтаар баталсугай.

2. Нэмэлтээр ажиллах эмнэлэг, тасгийг бэлтгэн, ажиллах эмч мэргэжилтний нөөцийн судалгааг гарган сургаж дадлагажуулах, шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хоол хүнсний бэлэн байдлыг хангаж нөөцийг бүрдүүлж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтэс (Н.Оюунтуяа), Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Ю.Ичинноров), Захиргаа санхүү, нийтлэг үйлчилгээний алба (Б.Валя)-д тус тус үүрэг болгосугай.

3. Шаардагдах нөөцийг бүрдүүлж санхүүжилтийг шийдвэрлэх болон зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймгийн нийт эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.ШИВААННҮРДЭВ

ЙЮЕ0007

018900012

D:My Doc.A4 tushaal /EMG/

ЭМГ-ын даргын 2020 оны 02 дугаар
сарын 16 ны өдрийн А/04 тоот
тушаалын хавсралт

ЙЮЕ0007

ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРЫН ҮЕД ДАЙЧЛАН
АЖИЛЛАХ ЭМНЭЛЭГ, ТАСАГ НЭГЖ

| № | Тасаг, эмнэлгийн нэр | Ажиллах орны тоо |
|---|---|---|
| 1 | БОЭТ-ийн халдвартын тасаг | 25 |
| 2 | БОЭТ-ийн сүрьеэгийн тасаг | 15 |
| 3 | БОЭТ-ийн сэтгэц, наркологийн тасаг | 15 |
| 4 | Ачтан-Ирээдүй хувийн хэвшлийн эмнэлэг | 50 |
| 5 | Чинмэнд хувийн хэвшлийн эмнэлэг | 30 |
| 6 | Ариунсанаа хувийн хэвшлийн эмнэлэг | 50 |
| 7 | Агь мамба хувийн хэвшлийн эмнэлэг | 20 |